

ЗҮҮН ХОЙД АЗИЙН БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

*С.Ёшида Сүсүмү**

Нэг. Олон улсын байдлын хувиралт

1989 онд хүйтэн дайн төгсгөл болж, ЗХУ задарсаны дараа АНУ дангаараа дэлхийд ноёрхох байдалтайгаар 2001 онтой золголоо. “9-р сарын 11-ний хэрэг явдал” гарсанаар олон улсын терроризм /аллага хядлага/-тай тэмцэх олон талын хамтын ажиллагааны цаг үе нэгэнт бий болов.

Олон улсын террорист байгууллага Афганистанд түшиц газар байгуулсаныг геополитикийн үүднээс үзвэл, Пакистан зэрэг эргэн тойрны улсууд терроризмтай тэмцэхэд идэвхитэй чухал үүрэг гүйцэтгэх юм. АНУ-ын зүгээс Орос, Узбекистан зэрэг Төв Азийн бүхий л оронд нэвтэрч цэргийн баазыг ашиглаж, мэдээллийн байгууллагуудтай нь хамтран ажиллах зэргээр хамтын ажиллагаагаа түргэн хурдацтай өрнүүлэхийг уриалав.

Америк-Хятадын харилцаанаас харахад, Бээжин олимпын тоглолтыг зохион байгуулах эрх олж авсанаар, Шанхайн Ази Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын /АРЕС/ хуралдаан амжилттай болж, Хятад улс дэлхийн худалдааны байгууллагад /WTO/ элсэж, Хятад Америкийн байнгын яриа хэлцээ бодит зүйл боллоо. Үүний зэрэгцээ “Шанхайн хамтын ажиллагааны байгууллага” оршин байгаа нь Хятад улсын олон улсын терроризмийн эсрэг хөдөлгөөнд гүйцэтгэх үүргийг нэмэгдүүллээ. Нөгөө талаар, Оросын Чечений дайн, Хятадын Синьзян-Уйгарын өөртөө засах орны аюулгүй байдлыг хангах арга хэмжээ нь олон улсын терроризмийн эсрэг хөдөлгөөний нэг хэсэг болж, олон улсын нийгмийн зүгээс зүй ёсны дэмжлэг олов.

Азид, Зүүн Өмнөд Азийн Улсуудын Холбоо /ASEAN/ ба Зүүн Азийн 3 улсын хуралдаан, Япон, Хятад, БНСУ-ын тэргүүн нарын хуралдаан болж; Япон Сингапурын хооронд чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулагдаж, мөн Япон-БНСУ-ын хооронд яг одоо энэ асуудлаар хэлэлцэн ярилцаж; Хятад ба АСЕАН-ы орнуудын чөлөөт

*Ёшида Сүсүмү - Япон улсын Зүүн хойт Азийн эдийн засгийн судлалын хүрээлэнгийн /ERINA/ захирал, профессор

худалдааны бүсийн хэлэлцээр байгуулах төлөвлөгөө /ажлын хэсгийн төлөвлөгөөгөөр 10 жилийн хугацаанд бүрэн дуусгана/ хэрэгжиж эхлээд байна. Энэ бүхэн нь дэлхийн эдийн засгийн төв аажмаар Зүүн Ази руу хандаж байгааг гэрчилж байна.

2000 онд БНАСАУ, БНСУ-ын буюу өмнөд, умардын удирдагчдын хэлэлцээр болсон нь Азийн аюулгүй байдлыг хамгаалах механизмд чухал нөлөө үзүүлээ. Өмнөд, умардын харилцаа хэдийгээр нэн их урагшилсан ч АНУ-ын ерөнхийлөгч Ж.Буш, Солонгосын хойгийн талаар Клинтонь засаг захиргааны бодлоготой адилгүй байр суурь баримталж буйн улмаас өмнөд, умардын харилцааны цаашдын хөгжил зогсох аястай байна. 2002 оны 1-р сарын 29-нд ерөнхийлөгч Ж.Буш “Терроризмтэй хийх тэмцэл” гэсэн илтгэлдээ БНАСАУ, Иран, Иракийг “хорон тэнхлэг” гэж нэрлэжээ. Үүнд Хятад, Орос, Өмнөд Европын олон орон өөр саналтай байна.

Ерөнхийлөгч Ж.Буш 2002 оны 2-р сард Хятад БНСУ-д айлчлахдаа БНАСАУ-ыг Иракаас ялган салгаж, БНАСАУ-тай яриа хэлэлцээ хийх бодлогыг гол болгохоо тодорхой илэрхийлэв. Энэ нь Бушийн засаг захиргаа БНАСАУ-тай бодит харилцааг эрхэмлэх бодлого явуулж болохыг харуулж байна.

Үүнээс гадна, цөмийн стратегийн тухайд, АНУ пуужингаас эсэргүүцэн хамгаалах гэрээ -/АВМ/-нээс ухарч, улмаар конгресст “цөмийн стратегиа засварлах” санал тавьсан зэрэг нь АНУ-ын “нэг талыг баримтлах” хандлага маш огцом илэрч байгааг харуулж байна.

Европын олон оронд Америкийг эсэргүүцэх сэтгэл санаа, Америкийн эсрэг ялангуяа, эргэн тойронд нь бий болсон өнөөгийн байдлын түүхэн улбааг эргэн харах хандлага өсөн нэмэгдэж, Америкийн үйл ажиллагаанд хориг тавьж, Иракийг довтлох асуудал дээр ихээхэн санал зөрсөөр байна.

Ийм байдалд холбогдох улсууд Афганд өрнүүлж буй олон улсын терроризмтэй хийж буй тэмцэлд олон талаар ижил байр суурьтай байна. Гэвч терроризмтэй хийх цаашдын тэмцэлд санал бүрэн нэг биш байгаа бөгөөд шинээр эсэргүүцэл гарах хандлага нэмэгдэх төлөвтэй. Үүсэн бий болсон эсрэг тэсрэг байдлыг арилгахын тулд, ерөнхийлөгч Буш 2002 оны 5-р сарын дундуур, Герман, Франц, Орост айлчиллаа. Оростой харилцах тухайд бол, Орос Америк хоёр цөмийн цэнэгт хошууг хорогдуулахаар хэлэлцэн тогтож, улмаар НАТО-д Оросыг элсүүлэхээр тогтов. Оросын тал буулт хийснээр Орос ба Европын харилцаа зузаарлаа.

2002 оны 6-р сард Шанхайн хамтын ажиллагааны байгууллага Санкт-Петербургт хуралдаж, Дундад Азийн цэргийн баазыг АНУ ашиглах асуудлаар нааштай шийд өгч, улмаар Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын дүрмийг баталлаа.

Хоёр. Улс хоорондын эдийн засгийн хамтын ажиллагааны харилцаа-хоёр талын хамтын ажиллагаа

1. ОРОС БА ХЯТАД

“Хятад Оросын хилийг тогтоосон хэлэлцээр” /1997 оны 11-р сар/, “Хятад, Оросын найрамдал, хамтын ажиллагааны гэрээ” /2001 оны 7-р сар/-гээр Хятад Оросын хооронд түүхээс үлдсэн асуудлыг шийдвэрлэж, найрсаг харилцаа тогтоов.

“Шанхайн 5 орон”-оос /1996/ “Шанхайн хамтын ажиллагааны байгууллага” /2001 оны 6-р сар/ хүртэл аюулгүй байдлыг хангах талаар олон талын хамтын ажиллагаа бүрэлдэн тогтов. /Харилцан үл довтлох, Исламын хуучин номлол нэвтэрэхийг хязгаарлах/ Хятад, Оросын хооронд /стратегийн хамтын ажиллагааны түншлэл/-ийн харилцаа тогтов.

2000 онд, Орос -Хятадын худалдаа 8 тэрбум ам. долларт хүрч, /Орос 4 дэх том худалдааны түнш болов/ 2001 оны 1-5-р сард Орос улс Хятадаас оруулсан импортын хэмжээ 870 сая ам. доллар болж өнгөрсөн оны мөн үеэс 22,2% өсөв. Оросын Хятад дахь экспорт 2,9 тэрбум ам.дол. хүрч 51,2% өсч, улмаар өсөн нэмэгдэх хандлагатай байна.

Хятад Оросын хэрэгжүүлж буй төслүүд гэвэл:

- Эрхүү мужийн Ковыктины байгалийн хийг ашиглах / урьдчилсан тооцоогоор бүтээн байгуулалтын зардал 10-11 тэрбум ам. дол./

- Ангарскаас Дацин хүртэлх 2400 км нефть дамжуулах хоолойн байгууламж /1,7 тэрбум дол/ 2005 оноос эхлэж жил бүр 20 сая тн, 2010 оноос хойш жил бүр 30 сая тн-оос дээш нефть дамжуулна. Хятадын холбогдох хүмүүсийн үзэж байгаагаар, Хятад улс 2005 онд нефтийн хэрэгцээ нь 140 сая тн, 2010 онд 260 сая тн-д хүрэх ажээ.

- Суйфэньхэ ба Хунчуньд Хятад Оросын чөлөөт худалдааны бүс байгуулагдаж, хил худалдаа улам өргөжиж байна.

- Хар мөрөн-Благовешенскийн хооронд хилийн том гүүр байгуулах.

2. ЯПОН БА ХЯТАД

2001 онд Япон Хятадын худалдааны хэмжээ 87,8 тэрбум ам. долларт хүрч, шууд хөрөнгө оруулалт 2001оны 6-р сарын байдлаар 29,7 тэрбум ам.доллар, иений зээллэгийн хэмжээ 224,5 тэрбум ам. доллар /1 ам. дол.=110 иен/ болов.

Хятад улс ДХБ-д элссэнээр санхүү, даатгал, гүйлгээ дотоодын худалдаа зэргийн орлого нэмэгдлээ.

Баруун бүс нутгийг нээж ашиглахыг дамжин том хэмжээний барилга байгууламж /хийг баруунаас зүүн тийш дамжуулах, баруунаас зүүн тийш цахилгаан дамжуулах, Төвдийн төмөр зам гэх мэт/ хүрээлэн буй орчныг хамгаалахад зарцуулах хөрөнгө оруулалт нэмэгдэж байна. Үүнээс гадна, дунд зэргийн хотын бүтээн байгуулалт хурдасаж гуравдагч салбар /үйлчилгээ/ өсөж, хөдөө тосгоны илүүдэл ажиллах хүчинг татаж, дотоод хэрэгцээг өргөтгөх, мөнгөний ханшны өсөлтийг сааруулахад нөлөөтэй байна.

Японы эдийн засаг аж үйлдвэрлэлийн яам ба Хятадын хөгжил төлөвлөлтийн улсын хороо Шэньси, Сычуань, Юньнань, Хармөрөн, Зилинь мужийг эдийн засаг, хамтын ажиллагааны үлгэр жишээ муж болгох, өөр хэлэлцэн тохиролцсон нь японы зээлийг давуутай ашиглах нөхцөлийг аажмаар бий болгож байна.

2002 оны 3-р сард Хятадын засгийн газар Хайнань аралд ДХБ-д элссэний дараах анхны Зүүн өмнөд Азийн хурал хийж, 5-р сард бас Шаньдун мужийн Вэйхай хотод Зүүн хойд Азийн эдийн засгийн индэр хуралдав. Үүний зэрэгцээ 5 сарын сүүлээр Хармөрөн мужид Япон Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны хуралдаан болж, улсын үйлдвэр аж ахуйн шинэтгэл, хөдөө аж ахуйн зэрэг асуудлаар санал солилцож, хөтөлбөрийг бодитой хэрэгжүүлэхийг уриалав.

3. ЯПОН БА ОРОС

Оросын эдийн засаг 1999 оноос эхлэн сэргэж эхэлж байна. Одоогийн байдлаар Японоос Орост 6 тэрбум ам. долларын мөнгөн тусламж олгохоор төсөвлөсөн ч бодит үр дүн нь дөнгөж 3 тэрбум байна. Одоогийн эдийн засгийн тусламжийн хүрээнд бэлэн мөнгийг КАМАЗ машины үйлдвэр, IZYNEVSK машины үйлдвэрийн тоног төхөөрөмж, /YAROSLAVL/ нефтийн шилдэг сайн төхөөрөмж авах зэрэгт хэрэглэж байна.

Одоо Японы эдийн засгийн хүрээнийхний гол анхаарч буй асуудал нь:

- Алс Дорнод, Байгалийн урт хугацааны хөгжлийн төлөвлөгөөг батлах /засварлаж шинэчлэсэн/
- Сахалины нефть, байгалийн хийг нээж ашиглахыг урагшлуулах
- Эрхүү муж Ковыктины байгалийн хийг ашиглах, хий дамжуулах хоолойн байгууламж
- Ангарскаас Находка хүртэлх нефтийн хоолойн байгууламж
- Ангарскаас Дашин хүртэлх түүхий нефть дамжуулах хоолойн байгууламж
- Алс Дорнодын суурь бүтээн байгуулалтын төлөвлөгөө /байгалийн хий дамжуулах хоолой, усан цахилгаан станц, боомт зэрэг 5 том хөтөлбөр/-ийн хэрэгжилт
- Тоног төхөөрөмжийг шинэчлэх технологийн өөрчлөлтийг хийхтэй холбогдох байгууллагын тоног төхөөрөмжийн иж бүрэн захиалга
- Давхар зээлийн системийн хэрэгжилт /олон улсын хамтарсан банк ба Орос улсын гадаад худалдааны банкны хоорондын хэлэлцээрээр тогтсон/
- Хоёр орны тэргүүн нар хэлэлцэн тогтсоны үндсэн дээр Япон, Оросын худалдааны хөрөнгө оруулалтыг ахиулах бүтэц бий болгох

4. БНАСАУ- ОРОС- ХЯТАД -ЯПОН

1990 онд хуучин ЗХУ БНСУ-тай дипломат харилцаа тогтоож, 1992 онд “Орос БНСУ-ын үндсэн гэрээ”-нд гарын үсэг зурсанаас хойш Орос, Ардчилсан Солонгосын харилцаа муудсан билээ. Гэвч 2000 оны 2-р сард “ОХУ, БНАСАУ-ын сайн хөрш, найрсаг хамтын ажиллагааны гэрээ”-нд гарын үсэг зурж, 2000 оны 7-р сард ерөнхийлөгч В.Путин БНАСАУ-д айлчилж, 2001 онд СХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ким Чен Ир Орост айлчилсан зэрэг дипломат үйл ажиллагааны үрээр хоёр талын харилцаа сайжирлаа. Хоёр тал “Владивосток-Чхонжин-Пхеньяны төмөр зам ба өмнөд-умардын төмөр замыг холбох төлөвлөгөө”-ний үндсэн дээр судалгаа хийлээ.

Эдийн засгийн талаар, Оросын тал Солонгост түүхий нефть, эрчим хүч нийлүүлэх зэрэг талаар туслаж байна. Эрчим хүчний талаар хамтран ажиллах тухайд Солонгосын хойгийн эрчим хүчийг нээж ашиглах байгууллага /KEDO/-ын харилцааг зохицуулах талаар Орос улс холбогдох улстай тохиролцох шаардлагатай юм.

2001 оны 1-р сард СХН-ын ерөнхий нарийн бичгийн дарга Ким Чен Ир ХКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга

Зянь Зэминь нар төрийн тэргүүний уулзалт хийж, мөн оны 9-р сард ерөнхий нарийн бичгийн дарга Зянь Зэминь Солонгост айлчлав.

Дээрх харилцан айлчлалаар дамжин Хятад, Солонгосын харилцаа хэвийн болох тийш хандаж байна. Үүний зэрэгцээ Хятад, Солонгосын хооронд үр тариа, нефть, чулуун нүүрс зэргийг нийлүүлэх асуудал илүүтэй анхаарах зүйл болоод байна.

Солонгосын хойгийн эрчим хүчийг нээж ашиглах байгууллага /KEDO/ -ын хамтын ажиллагаа, БНАСАУ Европын холбооны /EU/ 15 гишүүн орны 13-тай нь дипломат харилцаатай ба Солонгос нь дэлхийн эдийн засгийн системд эргэн орохыг хүсэж байна. БНАСАУ-ын асуудал дээр “АНУ, Хятад, БНСУ, БНАСАУ 4 улсын парламентийн яриа хэлэлцээний механизм”-д Япон Орос хоёр нэмэгдэж “6 улсын яриа хэлэлцээний механизм” болон өргөжив. Энэ нь Японы тухайд яривал маш чухал юм.

Үүнээс гадна, Ардчилсан Солонгосын эдийн засгийн бодлогод бага зэргийн өөрчлөлт гарлаа. 1999 оноос БНАСАУ-ын эдийн засаг өсөж, одоо аажмаар уналтаас гарч байна.

Ерөнхийлөгч Ж.Буш БНСУ-д айлчлахдаа ерөнхийлөгч Ким Дэ Жунтай хэлэлцээ хийж, АНУ-ын Хойд Солонгосын талаарх бодлогыг дахин зохицуулах боломж гаргаж, өмнөд, умардын төмөр замын байгууламж барих ажлыг боломжтой болов.

Япон-Ардчилсан Солонгосын харилцаанд харилцааг сэргээх, дайны төлбөр болон 80 тэрбум иений өрийг шийлдвэрлэх зэрэг асуудал оршиж байна.

5. ЯПОН БА МОНГОЛ

Мал аж ахуй өвлийн цас зудыг хэрхэн даван туулах нь мал аж ахуйг хамгаалж хөгжүүлэхэд маш чухал зүйл, түүнчилэн Япон Монголын цаашдын хамтын ажиллагаанд ч холбоотой юм.

Худалдааны харилцааны тал дээр, зэс, кашемир ямааны ноолуур хийгээд бэлэн бүтээгдэхүүн, алт, цайр импортлох нь өнөөгийн асуудал болж байна.

Япон жил бүр Монголд 6 тэрбум иений /55 мянган ам. доллар/ буцалтгүй тусламж үзүүлж байгаа ба одоо ч үзүүлсээр байна.

Нефтийн шинэ талбайг /75 мянган тн нөөцтэй/ нээж илрүүлээд байгаа ба нефтьтэй холбоотой үйлдвэр бий болгох нь өнөөгийн гол асуудал юм. Тус нефтийн талбай нь Хятадын Дациний нефтийн талбайд ойр учраас холбогдох талын техник технологийн хамтын ажиллагааны эрэл хайгуул хийж болох юм.

Үндсэн арга хэмээний талаар гэвэл цахилгаан станцийг шинэчлэх, одоо байгаа төмөр замыг засварлах зэрэг зорилт ид хэрэгжиж байна. Цаашид олон улсын дэмжлэгээр, Улаанбаатараас Чойбалсангийн авто зам барих ажил урагшлах бөгөөд Чойбалсангаас Эрчений /Ирши/ төмөр зам тавих зэрэг нь бодит ач холбогдолтой зүйл болох юм.

Гурав. **Зүүн хойд Азийн бүс нутгийн олон**

талт эдийн засгийн хамтын ажиллагааныг үнэлэх нь

Дээр дурдсанаар, энэ бүс нутгийн хоёр талын хамтын ажиллагаа маш их урагш ахилаа. Гэвч олон талын хамтын ажиллагаанд, Түмэн голыг нээж ашиглах нь олон талын хамтын ажиллагааны эмзэг газар болж байгаа ба 1995 оноос албан ёсоор ажилласнаас хойш үр дүн нь зөвхөн ачаа тээвэрлэх, нэвтрүүлэх, хот байгуулалт хийгээд жуулчлалыг хөгжүүлэх төдийгөөр л хязгаарлагдаж байна.

Тээврийн хонгилийг нээх

- Сүйфэньхэ -Уссурскийн хооронд төмөр замын тээврийг өргөтгөх

- Хуньчунь-Краскино-ийн хооронд төмөр зам тавих ба тээвэрлэлт хийх

- Шүцао-Зарубино /усан онгоцны гарц/-Хуньчунь /аялал бараа тээвэрлэлт/

- Хуньчунь-Нажин-Пусан- /нэг хэсэг нь Нийгатад хүрдэг/- Нийгатагийн агаарын замын контейнерийн тээвэр

- Посьет-Акита-гийн хооронд чингэлгийн тээвэр хийх

Хот байгуулалт

- Хуньчунь 30 мянган хүнтэй тосгон байснаа 210 мянган хүн амтай жижиг хот болон өргөжлөө.

- Нажинд манлайлагч эдийн засгийн тусгай бүс байгуулагдэн өргөжин хөгжиж, энэ бүс нутгийн аялал жуулчлалын үйлс өргөжлөө.

- Владивосток-Хуньчунь-Нажин /буюу Чинбайшань/

Гэвч эдгээр төлөвлөгөөнөөс харахад энэ бүс нутгийн олон талт хамтын ажиллагааны талаар ярихгүй байж болохгүй зүйл бол хаа хаанаа хоцрогдсон явдал юм.

Онолын үүднээс яривал, Япон ба БНСУ-ын хөрөнгө, техник технологи, Хятад ба БНАСАУ-ын хөдөлмөрлөх хүч ба зах зээл, Оросын байгалийн баялаг зэрэг нь бодит харилцан нөхвөрлөх шинжтэй юм. Эдгээр харилцан нөхөх давуу тал нь энэ бүс нутгийг

хөгжүүлэхэд чухал үүрэгтэй байх болно. Гэвч бодит байдлаас харахад, зөвхөн нэг хэсэг нөхөх давуу байдал хэрэгжих юм. Үүний шалтгаан юу вэ гэвэл.

1. Энэ бүс нутгийн хүйтэн дайны үед үлдэж хоцорсон маш олон асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй. Тухайлбал Япон, БНСУ, АНУ нь Ардчилсан Солонгостой харилцаа хараахан хэвийн болоогүй байна.

2. Энэ бүс нутагт өөр өөр нийгэм, эдийн засгийн байгуулал оршиж байна. Үүнд: Зах зээлийн эдийн засаг боловсоронгуй болсон улсууд /Япон, БНСУ/; шилжилтийн эдийн засагтай улсууд /Орос, Монгол/; социалист зах зээлийн эдийн засагтай улс /Хятад/; социалист улс /БНАСАУ/ зэрэг

3. Орон нутаг бүрийн засгийн газар энэ бүс нутгийн эдийн засгийн хөгжилд Төв засгийн газрын оролцоо, түвшинг дээшлүүлэхийг хүсэж байна. Гэвч бүрэн амжилтай гэж хараахан хэлж болохгүй юм.

4. Түмэн голын сав газрыг нээж ашиглах олон улсын хөтөлбөрийн холбогдох асуудал дээр, НҮБ-ийн хөгжлийн газраас /UNDP/ Япон улсыг албан ёсоор уг хөтөлбөрийн зөвлөлдөх хороонд оролцохыг урьсан хэдий ч Япон зөвшөөрөөгүй байна. Үүнээс гадна уг хөтөлбөрт оролцогч улс, хөрөнгийн хэмжээ чармайлтын түвшингийн тал дээр маш их зөрөөтэй байна.

5. Хөрөнгийг ашиглаж хэрэглэх санхүүгийн бүтэц байхгүй байна.

Дээр дурдсан шалтгааны улмаас сүүлийн 10 жилд ЗХА-ийн бүс нутгийн олон талт хамтын ажиллагаа харьцангуй ахиц муутай байна. Гэвч Хуньчунь, Нажин зэрэг олон өөр хотын хөгжил лавтай үр дүнд хүрсэн юм.

Дөрөв. ЗХА-ийн бүс нутгийн хамтын ажиллагаа

Хэдийгээр ЗХА-ийн бүс нутгийн олон талын хамтын ажиллагаа хөгжиж буй ч олон талт хамтын ажиллагааны хөгжлийн механизм хараахан бий болоогүй байна. Олон талт хамтын ажиллагааны хөгжлийг урагшуулахын тулд дараахь хэдэн чухал хөтөлбөрийг зайлшгүй хэрэгжүүлэх хэрэгтэй. Үүнд: Нэгдүгээрт:

1. Эрхүү мужийн Ковыктиныг байгалийн хийг ашиглах төв болгож, Азийн эрчим хүчний аюулгүй байдлыг хангах урт хугацааны систем бий болгох, одоогоор Хятад, Орос, БНСУ энэ хөтөлбөрийн хамтын ажиллагааны талаар ахиц олсон боловч Япон улс үүнд хараахан оролцохгүй байна.

2. Зүүн Хойт Азийн тээврийн хүчин чадлыг сайжруулах тээврийн хүчин чадлын хатуу хэрэгсэл төхөөрөмж ба зөөлөн орчны талын саадыг арилгах

3. Түмэн голыг нээж ашиглах /тухайлбал, Хуньчунь-Нажиний хооронд засмал зам тавих, Түмэн голын усны орчинг сайжруулах гэх мэт хөтөлбөр/

4. Жуулчлалыг хөгжүүлэх, жишээлбэл 2001 оны 8-р сард Япон тэнгисийн Зүүн эргийн Хуньчунь, Түмэн, Яньжи, Дунхай, Шүцао, Владивосток, Хамада, Сакахама, Комено, Увакоши гэсэн 10 хотын дарга нарын хурал хуралдсан юм. Энэ хурал дээр “Хотуудын жуулчлалыг харилцан хөгжүүлэх” сэдвийг хэлэлцсэн байна.

5. Улс бүрийн чөлөөт эдийн засаг, худалдааны онцгой бүсийн хооронд хэлэлцээ хийх. Вэйхайд болсон ЗХА-ийн индэр дээр, Владивосток-Инчон-Нийгата-ийн чөлөөт худалдааны бүс байгуулах төслийг дэвшүүлсэн юм. Одоо Японд онцгой бүс хараахан үгүй байна/

Эдгээр төслийг хөрөгжүүлэхийн тулд юуны өмнө, хөрөнгө оруулж, нээж ашиглах хөтөлбөрийн санхүүгийн системийг тодорхой болгох хэрэгтэй. Одоо байгаа олон төрлийн ЗХА-ийн хөгжлийн банк хийгээд ЗХА-ийн хөгжлийн санхүүжилтийг бий болгох. Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкнаас хөрөнгө гаргахаа дэвшүүлсэн төслийг ашиглах бүхий л саналын боломжтой эсэхийг судлах, бодитой саналыг хэрэгжүүлэх хэрэгтэй.

Хоёрдугаарт. Улс бүрийн Төв Засгийн газар олон талт хамтын ажиллагаа ба бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн талаар идэвхитэй стратеги бодлого баримтлах хэрэгтэй.

Гуравдугаарт. Одоо ЗХА-ийн эдийн засгийн хөгжлийн зорилтот хөгжлийн байгууллага тооны хувьд цөөн бус, нөлөөлөх хүч ихтэй хэд хэдэн байгууллага бий. НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр /UNDP/, ЗХА-ийн эдийн засгийн индэр, /Жао Лижи ноён/ Хятадын Төрийн Зөвлөлийн Түмэн голын бүс нутгийг нээж ашиглах удирдлагын бүлэг хийгээд ЗХА-ийн эдийн засгийн хуралдаан /Японы Нийгата/ гэх мэт. Эдгээр байгууллага өөр өөрсдийн бүс нутгийг өвөрмөц үйл ажиллагаагаар хөгжүүлж байна. Цаашид харилцан явуулах үйл ажиллагаагаа зохицуулж хамтын ажиллагаагаа нэмэгдүүлвэл үйл ажиллагаа нь улам үр бүтээлтэй байх болно.

Хятад хэлнээс орчуулсан **Л.Бэгзжав**